

“Зүрхэн толтын тайлбар” дахь “амин үсэг”-ийн тухай ойлголт

Д.Цэрэнпил
МУИС. МХСС

1. Гунгаажалцаны 44 үсэг.
2. "Амин үсэг"-ийн тухай ойлголт.
3. "Амин үсэг"-тэй холбоотой ойлголтууд.
4. "Амин үсэг"-ийн тухай ойлголт төвөд хэлзүйн бичигүүдэд.
5. "Амин үсэг"-ийн үсэгзүйн асуудал

1. Монгол хэлний хэлзүйн болон түүхийн сурвалж бичгүүдэд Сажа бандида Гунгаажалцан монгол хэлний цагаан толгойн үндэсэн 44 үсэгийг зохион үйлдсэн тухай нэгэн дуугаар "нотлон"² бичсэн байдаг. Ингэхдээ,

- эсвэл Сажа бандидын үсэгийн зөвхөн тоог нь 44 гэж дурдсан байдаг.
- эсвэл тэдгээрийг бүгдийг нэгбүрчилэн үет үсэгийн байдлаар тоочин жагсаасан байдаг. Тухайлбал, "Зүрхэн толтын тайлбар -Огторгуйн маань"-д:

1. *a, e, i*
2. *na, ne, ni*
3. *ba, be, bi*
4. *γa, ge, gi*
5. *qa, ke, ki*
6. *ma, me, mi*
7. *la, le, li*
8. *ra, re, ri*
9. *sa, se, si*
10. *da, de, di*
11. *ta, te, ti*
12. *ja, je, ji*
13. *ča, ce, ci*
14. *ya, ye, yi*
15. *wa, we*

[Данзиндагва, 1727-1735?,46]

Гэтэл Сажа бандида эдгээр 44 үсэгийг хэрхэн гарган авсан тухай асуудал судлаачидын анхааралыг ихэд татдаг. Энэ талаар 2 үндэсэн санал байна. Үүнд:

- 14 гийгүүлэгчийг *a, e, i* гэсэн гурван эгшигээр амилуулж *wi*-г хасаад 41 үе-үсэг гарган авч дээр нь гийгүүлэгчидийг амилуулсан 3 эгшигийг нэмж 44 үсэг болгосон. [Пагба,1957.11; Балданжапов,1962.А.21]
- Уйгарын 14 (*a, n, b, γ, q, m, l, r, s, d, t, y, č, j*) үсэгийг *a, e, i* гэсэн 3 эгшигээр амилуулж 42 үе-үсэг гарган авч дээр нь тусгай зориулалт бүхий *wa, we* (энэ нь *w*-г *a/e*-гээр амилуулсан хэрэг биш) гэсэн хоёр үе-үсэгийг нэмж 44 үе-үсэг болгосон. [Лувсанвандан,1965; Төмөртогоо,1973]

² Энэ тухай нэгэн домогийг монголын түүхийн болон хэлзүйн бичигүүдэд олонтаа дурдсан байдаг. Гэвч энэ нь зөвхөн домог төдий зүйл бололтой. Проф. Д.Карагийн бичсэнчилэн: "Сажа бандида үнэхээр монгол-төвдийн харилцаа холбооны түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэсэн нь үнэн боловч харин бичиг үсэг зохиосон нь үгүй билээ" [1972.16].

Зарчимын ялгаатай энэ хоёр саналыг харьцуулан үзэхэд хэлзүйн бичигүүдэд тусгалаа олсон уламжлалт хэлшинжлэлийн зарим чухал ойлголтод холбогдох хоёр асуудал анхаарал татаж байна. Тухайлбал:

- Эгшигээр (*a, e, i*) амилуулсан 14 гийгүүлэгчид *w*-г оруулсан эсэх. Хэрэв оруулсан бол *wi* үе үсэгийг онцлон хасах шаардалга юу байв? Хэрэв оруулаагүй бол *wa, we* гэсэн хоёр үе-үсэгийг нэмэх шаардалга юу байв?
- Уйгарын 14 үсэгийг (*w* орохгүй) *a, e, i* гурван эгшигээр амилуулж 42 үе-үсэгийг бүтээх тухай ярихад тэдгээр 14 үсэгийн эхний үсэг *a*-г *a, e, i* гурван эгшигээр амилуулахыг юу гэж ойлгох вэ? Энэхүү эхний үсэг *a* нь эгшиг үү, гийгүүлэгч үү? Аль эсвэл юу вэ?

Эхний асуудалын тухайд акад. Д.Төмөртоогоо "Сажа бандидын 'Зүрхэн Толта' дахь *wa, we*-гийн тухай" [1973] гэсэн илтгэлдээ энэ талаар тодорхой санал дэвшүүлсэн. Харин *wi*-г хассан тухайд түүнийг хасах тухай ярих нь байтугай ерөөсөө монгол хэлэнд '*wi*' гэсэн үет үсэгийг хэрэглэдэггүй, мөн түүнчилэн уруулын гийгүүлэгчээр амилуулсан *wo, wu, wö, wii* гэсэн үеүдийг ч мөн хэрэглэдэггүй тухай нэгэн сонирхолтой баримт байна. Үүнд, Агваандандар "Хэлний чимэг" [1828.2a] хэмээх бүтээлдээ: "*basa wa, we qoyar mongyol-un üge-dür bui böged wi, wo, wu, wö, wii ene tabun üsüg mongyol-un üges-dür üliü kereglekü böged...*" хэмээн бичсэн байдаг нь, нэг талаас, *wi*-г яагаад хассан тухай ямар нэг тайлбар хийх шаардалгагүй болохыг харуулж, нөгөө талаас, акад. Д.Төмөртоогоогийн дэвшүүлсэн '*wa, we*'-гээр уруулын эгшигүүд болон тэдгээрээр амилуулсан үеүдийг хураангуйлан тэмдэглэсэн болохоос биш *w*-г 14 гийгүүлэгчийн тоонд оруулж анхдагч гурван эгшигээр амилуулсан хэрэг биш гэсэн саналыг давхар батлаж байна. Харин хоёрдахь асуудалын тухай хойно тусад нь авч үзье.

2. Бараг бүх уламжлалт хэлзүйн бичигүүдэд эгшиг үсэгүүдийг титэмтэй хэлбэрээр, харин гийгүүлэгч үсэгүүдийг үе-үсэгийн байдлаар бичиж тэмдэглэсэн байдаг билээ. Ихэнхи судлаачидын үзэж байгаагаар, хэдийгээр уламжлалт хэлзүйн бичигүүдэд үе-үсэгийг хэрэглэж ирсэн боловч монгол бичиг нь авианы бичиг бөгөөд үсэгийг үеийн хэлбэрээр тэмдэглэдэг тогтсон хэв загвар нь угтаа энэтхэг-төвдийн хэлшинжлэлээс уламжлалтай юм.

Гэтэл энэ уламжлалаас гажиж эгшиг, гийгүүлэгчийг үе-үсэгийн хэлбэрээс ангид тусад нь биеэ даасан авианы байдлаар бичиж тэмдэглэсэн нэгэн хэлзүйн бичиг байдаг нь XVIII зууны монголын томоохон хэлзүйч Урад гүүш Билигийн Далай (Шаравжамц) -н бичсэн "Монгол үсэгийн ялгал ба махбодийн өчүүхэн товчинууд" (А) хэмээх зохиол юм. Акад. Д.Төмөртоогоогийн дүгнэсэнчилэн, "... Билигийн Далайн зохиолууд нь урьд Чойжи-Одсэрийн зохиосон "Зүрхэн толтын тайлбар"-ын гол агуулгыг тусгасанаараа Данзиндагвын "ЗТТ-ОМ" -тай мөр зэрэгцэхүйц чухал ач холбогдолтой юм. Данзиндагва Чойжи-Одсэрийн "ЗТТ"-ын гол агуулгыг нэгэн зохиолд багтаан тайлбарласан бол гүүш Билигийн Далай түүний бөлөг хэсэгүүдийг салган тайлбарласан хэд хэдэн зохиол бичжээ. ... Билигийн Далайн зохиолууд нь Данзиндагвын зохиолтой олон талаар тохирч байгаа нь түүний зохиолоос авсан биш, харин Данзиндагвын нэгэн адил Чойжи-Одсэрийн "ЗТТ"-т тулгуурлан зохиолоо бичсэнтэй холбоотой юм" [1981.48]. Үүнийг Билигийн Далайн зарим зохиолын төгсгөлийн үг ч батлаж байна [Б.15а; В.6а-6б]. Тиймээс Билигийн Далайн зохиол дахь гол санаанууд нь Сажа бандида Гунгаажалцан, Чойжи-Одсэр зэрэг эрт үеийн хэлзүйчидийн үзэл баримтлалыг тусгасан бөгөөд зөвхөн хожуу үеийн хэлшинжилэлд хамаарах зүйл биш гэж үзэх үндэстэй юм.

Билигийн Далай зохиолынхоо хамагийн эхэнд: *"amin üsüg inü 'f ' kemekü nigen bui. egešig üsüg inü f, f, i, o, o, oï, oï ([a], [e], [i], [o], [u], [ö], [ü]) edeger yurban er-e, yurban em-e, nige sayarmaḡ luḡ-a doluḡan böged, nige törül-iyer kemegsen neretü boluju amin üsüg-dür egešig oruqu kemegsen inü amin üsüg-dür doluḡan egešig oruju fa, ft, fl, Fo, Fo, Foï, Foï (a, e, i, o, u, ö, ü) boluḡsan metü bolai"* [А.16] гэж бичсэн байна.

Энд бичсэнийг сийрүүлбэл:

- Юуны өмнө "амин үсэг" хэмээх нэгэн ойлголтыг дурдаад түүнийг богино шүдний хэлбэрээр тэмдэглэсэн байна.
- Эгшиг нь гурван эр, гурван эм, нэг саармаг бүгд долоо байна гэдэгийг дурдаад тэдгээрийг үе-үсгийн бүрэлдэхүүнд амь өгч ордог хэлбэрээр, өөрөөр хэлбэл амь авч буй гийгүүлэгчээс нь салангид хэлбэрээр тэмдэглэсэн байна.
- "Амин үсэг"-ийг дээрхи долоон эгшигээр амилуулж "нэгэн төрөлөөр" ('a'-гийн төрөлийн) хэмээх бүлэгийг гаргадаг тухай дурдаад тийм нийлмэл бүтэцийг эгшигийн үгийн эхэнд ордог титэмтэй хэлбэрээр тэмдэглэсэн байна.

Үүнээс үүдэн дараахи хэдэн санааг хэлж болохоор байна. Үүнд:

- a) Уламжилалт хэлзүйн бичигүүдэд эгшигийг тусгайлан дурдахдаа үгийн эхэнд орсон титэмтэй хэлбэрээр бичиж заншсан билээ. Энэ нь угтаа түрүү үеийн монгол хэлзүйчид эгшигийн биеэ даасан хэлбэрийг 'амин үсэг + эгшиг' гэсэн нийлмэл цогц буюу нэгэн төрөлийн үе-үсэг мэтээр ойлгож байсанаас улбаатай болохыг Билигийн Далайн дээрхи тайлбар тодорхой харуулж байна.
- b) Билигийн Далай "амин үсэг"-ийг нийлмэл цогцоос нь механикаар салган шууд титэм хэлбэрээр бичсэнгүй, харин богино шүдээр бичсэн нь түүнийг уйгарын 14 үсэгийн эхний *a* үсэг болохыг онцлон зааж байна гэж үзвэл зохино. Тэгээд ч титэм бол уйгарын *a* үсэгийн хожимын хувилбар гэдэг нь эргэлзээгүй билээ [Кара,1972.34; Шагдарсүрэн, 1981.16].
- c) Билигийн Далай "амин үсэг"-ийг эгшиг үсэгийн өмнө тусад нь тодорхойлж "... хэмээх нэгэн буй" гэж цохон дурадсан нь түүнийг эгшигээс зарчимын ялгаатай зүйл гэж үзэж байсаныг тодорхой харуулж байна.

Энэ бүгдээс үзвэл "амин үсэг" гэдэг нь уйгарын хэмээгдэх монгол бичигийн анхан 14 үсэгийн эхний үсэг - *a* үсэгийн нэр бөгөөд дараахи хоёр үүрэгтэй байна:

- Цагаан толгойд эгшигийн төрөлийг төлөөлнө. Жишээлбэл, *a*-гийн төрөлийн үсэг гэвэл долоон эгшигийг хэлж буй мэт.
- Бие даасан салангид эгшигийг бичигт тэмдэглэхэд тухайн эгшигээр амилагдаж нэгэн төрөлийн үе үсэг бүтээх толгой гийгүүлэгчийг төлөөлнө. Жишээлбэл, [a] эгшигийг бие даасан салангид хэлбэрээр бичихдээ "амин үсэг" (титэм)-ийг [a] эгшигээр амилуулах мэт.

3. Монгол хэлзүйн бичигүүдэд "амин үсэг"-тэй холбоотойгоор "ах үсэг", "эх үсэг", "хан үсэг", "ахмад үсэг" зэрэг нэр томъёог хэрэглэсэн байдаг. Тухайлбал, "ЗТТ-ОМ"-д эгшигийн тухай тодорхойлолт өгөхдөө "ах үсэг", "эх үсэг"-ийн тухай дураджээ: Түүнийг эш татвал: *"angq-a* (эгшиг - Д.Ц) *anu a, e, i, o, u, ö, ü bolai. edeger-i aq-a üsüg buyu uu, eke üsüg kemekü bolai. yaḡun-u tula kemebesü edeger üsüg törül-iyer-iyen*

qamiḡ-a bičibesü-ber üges-ün eke bolqu-yin tula teyin kemen ögülebei. jirüken-ü tolta-ača ügüs-ün aqa inu alin bui kemebesü a, e, i, o, u, ö, ü doluyula törül-iyer-iyen aq-a üsüg buyu kemebei. egešig üsüg ami ese oruḡsan üsüg ügei bolai... egešig orul ügei ögülejü ülü bolqu" [Данзиндагва, 1727-1753?.10a]. Үүнийг анхааралтай уншиж үзвэл зарим санааг тодруулж болохоор байна.

Долоон эгшигийг, өмнө дурадсанчилан, титэмтэй хэлбэрээр бичээд эгшигийг тодорхойлохдоо юуны өмнө тэдгээрийг "ах үсэг" ба "эх үсэг" гэж нэрлэдэгийг онцлон дураджээ. Гэвч зарим судлаачидын үздэгчилэн [Балданжапов, 1962.Б.58; Парба, 1957.11] эгшиг үсэгийг ингэж нэрлэж байгаа хэрэг биш, харин энд дурадсан эгшигийн титэмтэй хэлбэрийг ингэж нэрлэж байна гэж ойлгох нь зүйтэй. Үүнд: *edeger-i* гэсэн заах төлөөний үг нь *angq-a* (эгшиг) гэдэгт холбогдож байна уу, эсвэл *a, e, i, o, u, ö, ü* гэсэн долоон хэлбэрийг зааж байна уу гэдэгийг бодох хэрэгтэй. Заах төлөөний үгийн олон тооны хэлбэрийг хэрэглэсэн, дараагийн өгүүлбэрт *edeger üsüg* гэж бичсэн зэрэгээс дээрхи дүгнэлтийг хийж болно.

Эгшигийн тухай тодорхойлолтоос харахад "ах үсэг", "эх үсэг" гэдэг нь утгын хувьд ялгаагүй бөгөөд "ах үсэг" гэсэн нэр томъёо нь түрүү үеийн зүрхэн толтуудад хэрэглэгдэж байсан хийгээд хожим Данзиндагвын үед эр, эм үсэгийн эсрэгцэлийг заан "эх үсэг" гэсэн нэр томъёог нэмэж хэрэглэсэн бололтой.

Хожуу үеийн хэлзүйн бичигүүдэд мөн "хан үсэг" гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Тухайлбал, Лхамсүрэнгийн "Алтан толь" хэмээх хэлзүйн бичигт: *"a ayimaḡ-un doluyan üsüg bolbasu üsüg jaḡaju bičiküi-dür dumda ba aday-tur oruqu yosun ügei-yin tulada qan üsüg kemen nereyidtügen ba daray-a olan üsüg-i čöm ene doluy-a-yin ayahyu-bar dayudaqu bolqu-yin tula egešig üsüg kemen nereyidtügen bui"* [1903.7a] гэж бичжээ. Үүнээс үзвэл:

- "a аймагийн долоон үсэг" нь үгийн эхэнд орох титэмтэй хэлбэр буюу нэгэн төрөлийн үе-үсэг тул үгийн дунд ба адагт орох ёсгүй гэдэгийг тайлбарлаад "хан үсэг" гэж нэрлэжээ.
- Бусад үсэгийг "энэ долоогийн аялгуугаар" (энэ долоон эгшигээр биш, энэ долоогийн эгшигээр) амилуулах тул "эгшиг үсэг" гэж нэрлэжээ.

"Хан үсэг"-ийн тухай ийм ойлголтыг Агваандандарын "Хэлний чимэг"-т бас дурадсан байна. Үүнд: *"... busu basa edeger doluyan üsüg üge-yin ekin-dür bičiküi-čče anggida dumda ba aday-dur bičiküi yosun ügei-yin tula qan üsüg-čü kememüi"* [1828.26-3a]

Тэгвэл "хан үсэг", "эгшиг үсэг" гэсэн хоёр ойлголт адилгүй бөгөөд нэг нь нөгөөдөө багтсан ойлголт юм. "Хан үсэг" нь утгынхаа хувьд өмнө дурадсан "ах үсэг", "эх үсэг" гэсэн ойлголтуудтай дүйж байна. Харин тэдгээр нь өөр өөр үед, тухайлбал, "ах үсэг" - XIII зууны үед буюу Гунгаажалцан, Чойжи-Одсэрийн зүрхэн толтуудад, "эх үсэг" - XVIII зууны үед буюу Данзиндагвын "ЗТТ-ОМ"-д, "хан үсэг" (мөн "ахмад үсэг") - XIX-XX зууны үед буюу Агваан, Лхамсүрэн, Дэлэгжунайн зохиолуудад хэрэглэгдэж байжээ.

4. "Амин үсэг" гэдэг нэр томъёо төвөд хэлзүйн бичигүүдээс уламжлалтай юм.

Төвөд хэлний цагаан толгойн эцэсийн ^ᠮ үсэгийг *stog gi yi ge* буюу "амин үсэг" гэдэг [Бадараев, 1967.83]. Энэхүү ойлголт нь энэтхэг-төвөдийн уламжлалт хэлшинжлэлийн тулгуур зарчим болох "urāya-prajñā" буюу арга билигийн зарчмыг хэлний үзэгдэлийг тайлбарлахад хэрэглэж байсаны нэгэн жишээ юм. Тухайлбал, хэлний авиаг эгшиг,

гийгүүлэгч гэж ангилахад тэдгээрийн бие биенээ нөхцөлдүүлсэн, нэг нь нөгөөгүйгээр эс орших мөн чанарыг илтгэж, эгшигийн тухайд гийгүүлэгчийн, гийгүүлэгчийн тухайд эгшигийн үүрэг гүйцэтгэх хоёрдмол шинжтэй, эгшиг, гийгүүлэгчийн хоорондохи харьцааны амин сүнс болсон бичлэгийн махбодийг "амин үсэг" гэж нэрлэсэн байна.

Арга билигийн зарчимаар эгшиг, гийгүүлэгчийн мөн чанарыг тодорхойлохдоо нэгийг нь нөгөөгөөс нь салшгүй харьцаанд авч үздэг. Тухайлбал, эгшигийн мөн чанар бол гийгүүлэгчид амь өгөх, гийгүүлэгчийн мөн чанар бол эгшигээр амь авах, эгшиг нь гийгүүлэгчээс, гийгүүлэгч нь эгшигээс салангид оршихгүй, тэдгээрийг бие биенээс нь ангид хэлж бичих боломжгүй, гийгүүлэгчийг амилуулаагүй эгшиг бол эгшиг биш, эгшигээр амилагдаагүй гийгүүлэгч бол гийгүүлэгч биш гэж үздэг.

Арга билигийн энэ зарчим хийгээд "амин үсэг"-ийн талаар төвөд хэлзүйн бүтээлүүдэд хэрхэн авч үзсэнийг товч дурадъя¹.

Төвөдийн эрдэмтэн Шалу-лозава Чойжинсамбу төвөд хэлний хэлзүйн томоохон тайлбартаа *sum cu pa ni phyogs lhung med* (гучит нь хязгаар үгүй) гэсэн хэллэгийг *sum cu pa a yig/ de yi ge phal che ba la srog tu gnas pas so* (гучит нь ^ᠮ үсэг болой. Тэр үсэг нь чухамдаа амин-дор орох ажгуу) [Чойжинсамбу, 1526.18a] хэмээн тайлбарласан байна. Мөн тэрбээр төвөд хэлзүйн үндэсэн сударын (мөн цагаан толгойн) нэр "гучит" нь олонхи эрдэмтэдийн үздэгчилэн "гучин үсэгтэй" [Перих,1961.38] гэсэн утгаар биш, харин цагаан толгойн эцэсийн гучдахи онцгой үсэг ^ᠮ -г заан нэрлэсэн болохыг тэмдэглэсэн байна. Мөн ийм санааг төвөдийн алдарт эрдэмтэн Янжингавилодой [26] дурадсан байдаг.

Монголын нэрт хэлзүйч Агваандандар өөрийн зохиосон төвөд хэлзүйн бичигтээ ^ᠮ үсэгийн мөн чанарын тухай тодорхой тайлбарлан бичжээ. Үүнд: *a la dbyangs 'jug med pas na/ gsal byed yin gyi a ma gtogs/ lhag ma nyi shu rtsa dgu ni/ a yi dbyangs kyis brjod pa'I phyig/ a yang dbyangs su 'du bar 'dod gal te a dbyangs mi 'dod na/ a yi dbyangs nges med 'byur zhin/ i sogs gang rung shugs min pa'i/ ka sogs brjod pa'I tshul la sogs/ med par thal ba gang gis bzlog* (^ᠮ -г эгшиг-дор үл тооцох авч гийгүүлэгч-дор бас үл тооцмуй. Үлдсэн хорин есийг ^ᠮ -ийн эгшигээр амилуулах тул ^ᠮ эгшиг болой. Хэрэв ^ᠮ -г эгшигээр үл амилуулбаас ^ᠮ тэргүүтэн (эгшигүүд) ^ᠮ тэргүүтэн (гийгүүлэгчидийг) үл нөхцөлдүүлэх болой) [А. 3б-4а]. Үүнээс үзвэл, ^ᠮ нь эгшиг ч биш, гийгүүлэгч ч биш, гэхдээ аль алиных нь шинжийг хадгалсан. Өөрөөр хэлбэл, ^ᠮ эгшигээр амилуулаагүй гийгүүлэгч бол гийгүүлэгч биш, мөн түүнчилэн ^ᠮ гийгүүлэгчийг амилуулаагүй эгшиг бол эгшиг биш гэж үзсэн байна. Үүнийг бүдүүвчээр үзүүлбэл:

$$\begin{matrix} \text{ᠮ} & + & \text{ᠮ} & = & \text{ᠮ} & & \text{ᠮ} & + & \text{ᠮ} & = & \text{ᠮ} \end{matrix}$$

Энэ зарчмыг үл харгалзсанаас орчин үеийн судалгаануудад төвөд хэлний эгшигүүдийг *i, u, e, o / ˆ, ˇ, ˘, ˇ /* гэж бичсэн зүйл тааралддаг [Балданжапов, 1962.Б.8]. Тэгвэл төвөд хэлний *a* эгшигийг яаж бичих вэ? Эдгээр дүрс нь ^ᠮ үсэгээс ангид ямар ч утгагүй зүйл юм. Зүйрлэн хэлбэл Ё-гийн хоёр цэг нь Е-гүйгээр утгаа алдах

¹ Энэ талаар дэлгэрэнгүй үз: [Д.Цэрэнпил, 1987]

мэт. Тэгвэл төвөд хэлний 5 эгшигийг ᠮ , ᠨ , ᠯ , ᠪ , ᠶ гэж бичих нь зүйтэйг энэ зарчим харуулж байна. Гэвч энэ нь зөвхөн орчин үеийн судлагаанд харагддаг зүйл биш юм. Төвөдийн нэрт эрдэмтэн Лондол лам Агваанлуvsан төвөдийн хэлзүйчид энэ зарчмыг тэр бүр ойлгохгүй байгааг шүүмжлээд эгшиг, гийгүүлэгчийн харьцаанд ᠮ үсэгийн гүйцэтгэх онцгой үүрэгийг дурадсан байдаг. Тэдгээрийн олонхи нь ᠮ үсэгийг гийгүүлэгч гэж үзээд төвөд бичигийн 30 гийгүүлэгчийн тоонд оруулдаг нь [Рерих, 1961.38, мөн зүүлт 5] энэ зарчмын зөвхөн нэг талыг онцлосон хэрэг юм.

Орчин үеийн хэлшинжлэлийн бүтээлүүдэд төвөд хэлний "амин үсэг"-ийн тухай болон эгшиг, гийгүүлэгчийн мөн чанарыг арга билигийн үүднээс авч үзэхэд түүний гүйцэтгэх үүргийн тухай зөв зүйтэй үнэлэлт дүгнэлт өгсөн зүйл багагүй байдаг. Тухайлбал, "Төвөд бичигт гийгүүлэгч, эгшигийг хэвтээ тэнхлэгийн өөр өөр түвшинд (эгшигийг гийгүүлэгчийн дээр буюу доор) байхаар зохиохдоо үеийг бүтээх энгийн аргыг хэрэглэсэн нь эгшигийг төлөөлсөн ерөнхий тэмдэгийг гийгүүлэгчийн үндсэн түвшинд суулгаж өгсөн явдал юм. Энэ эгшигт *a* гэсэн ерөнхий эгшигийн утгыг өгчээ" [Амирова, 1975.76]. "Төвөд хэлзүйн уламжлал нь биеэ даасан цэвэр гийгүүлэгч, цэвэр эгшигийг хүлээн зөвшөөрч чадахгүй бөгөөд цагаан толгойн бүх гучин үсэгийг, түүний дотор ᠮ үсэгийг *gsal byed* (гийгүүлэгч)-ийн бүлэгт оруулан авч үздэг. Тийнхүү ᠮ -г гийгүүлэгч гэж үзвэл тэр нь авиазүйн хувьд гийгүүлэгчийн махбодь ба *a* эгшигээс бүрдэх ёстой. ᠮ үсэг нь биеэ даан зөвхөн үгийн эхэнд бичигддэг [Бадараев, 1967.41-42] гэх зэрэгээр бичсэн байна.

Төвөд хэлний "амин үсэг" хийгээд түүний үүрэгийн талаар дээр өгүүлсэнээс үзэхэд төвөд хэлшинжилэлийн энэ ойлголт монгол хэлзүйн бичгүүдэд шууд тусгалаа олсон нь тодорхой харагдах бөгөөд монгол хэлний "амин үсэг"-ийн тухай бидний дүгнэлтийг давхар батлаж байна.

5. Дээр дурадсан санааг үсэгзүйн талаас нь батлах сонирхолтой баримтууд бас байна. Проф. Г.Д.Санжеев: "Хэрвээ хуучин монгол цагаан толгойн эгшиг үсэгүүд хийгээд тэдгээрийн үгийн эхэнд орох дээрхи нийлэмжүүд *e*-гээс бусад эгшиг авиаг илэрхийлэхдээ "богино шүд"-ний ижил хэлбэр болох "титэм" буюу "толгой"-г авдаг" гэжээ [1977.22]. Титэм нь үгийн эхний богино шүднээс үүсэлтэй бөгөөд үгийн эхний эгшигийн дээр бичигддэгийг Д.Кара, Ц.Шагдарсүрэн зэрэг эрдэмтэд тэмдэглэсэн байдагийг өмнө дурадсан. Энэ нь эгшиг үсэг үгийн эхэнд бие даан бичигддэггүй, нэг ёсондоо титэмийг амилуулдаг гэж үзсэн хэрэг юм. Тэгвэл эндээс үгийн эхний богино шүдээр тэмдэглэх *a* үсэг, гийгүүлэгчийг амилуулах *a* эгшиг хоёрын ялгааг тодорхой харж болно.

Харин аналогоор бодоход титэмийн дор *e* үсэгийг тэмдэглэсэн дүрс үгүүлэгддэг. Гэвч богино шүд (*aleph*), урт шүд (*yod*), гэдэс (*waw*) зэрэг дүрс бүгд ашиглагдсан байх тул *a*, *e* эгшигийн бие даасан буюу үгийн эхэнд орсон хэлбэрийг ялгах шаардалгын үүднээс төвөдийн хэлшинжлэлийн дэгийг баримтлагч монгол бичигийг зохиогчид *e*

эгшигийн хувьд тайлал хийсэн гэж үзүүштэй. Үүнийг тод үсгийн бичилбэрээс тодорхой харж болно. Зая-бандида тод үсгийг зохиохдоо хуучин монгол цагаан толгойн үсгийг аль болох хэвээр хадгалахыг эрмэлзэхийн зэрэгцээ түүний олон дуудлагат шинжийг халахын тулд дорвитой өөрчлөлтүүд хийсэн билээ. Проф. Санжеевын хэлсэнчилэн, хэлбичигийн боловсролоороо XIII зууны хэлзүйчидээс хавьгүй өндөр байсан [1977.63] тэрбээр *e* эгшигийн талаархи дээр дурадсан зарчимын дутагдалыг арилгаж титэмийн дор бичих шинэ махбодь зохион хэрэглэсэн нь "амин үсэг"-ийн тухай бидний ойлголтыг давхар батлаж байна.

Ном зүй

- Агваандандар, 1828 - aybandandar, mongyol üsüg-ün yosun-i sayitur nomlaysan kelen-ü čimeg kemegdekü orušiba, модон бар
- Агваандандар, А - a lag sha bstan dar sum cu pa dang rtags 'jug gi don go sla bar bsdus pa'i bshad pa skal ldan yid kyi pad ma 'byed ba'i snang ba'i mdzod ces bya ba zhugs so / Агваандандарын зохиолын эмхэтгэл, Гумбум хэвлэл, 2-р боть 22-р зохиол
- Амирова, 1975 - Т.А.Амирова, Б.А.Ольховиков, Ю.В.Рождественский, "Очерки по истории лингвистики", М.
- Бадараев, 1967 - Б.Д.Бадараев, "Об основах транскрипции и транслитерации для тибетского языка", Улан-Удэ.
- Балданжапов, 1962.А - П.Б.Балданжапов, "JIRÜKEN-Ü TOLTA-YIN TAILBURI - монгольское грамматическое сочинение XVIII века" монгольский текст, сводный текст и перевод. Введение и примечания/, Улан-Удэ.
- Балданжапов, 1962.Б - П.Б.Балданжапов, "KELEN-Ü ČIMEG" монгольское грамматическое сочинение XIX века" монгольский текст, сводный текст и перевод. Введение и примечания/, Улан-Удэ.
- Билигийн Далай, А - bilig-ün dalai, mongyol üsüg-ün ilγal ba maqabud-un öčüken tobči, модон бар, Фото хуулбар: [Балданжапов, 1962.А]
- Билигийн Далай, Б - bilig-ün dalai, mongyol üsüg-ün tolta-ača öčüken jiyabari, модон бар, Фото хуулбар: [Балданжапов, 1962.А]
- Билигийн Далай, В - bilig-ün dalai, mongyol üsüg-ün kürtegel jirüken tolta, модон бар.
- Данзиндагва, 1727-1735? - danjindayba (amon lam rab byams pa bstan 'dzin grags ba), jirüken-ü tolta-yin tayilburi üsüg-ün endegürel-ün qarangyui-yi arilγayči oytaryui-yin mani, модон бар, Фото хуулбар: [Балданжапов, 1962.А]
- Кара, 1972 - Д.Кара, "Книги монгольских кочевников", М.-Л.
- Лувсанвандан, 1965 - Ш.Лувсанвандан, "Эртний монгол хэлний фонемийн систем нь" -Studia Mongolica, t. V
- Лхамсүрэн, 1903 - lhamosürüng, mongyol üsüg-ün yosun-i todurqayilan γarγaysan altan toli kemegdekü orušiba, "Монгол хэл бичиг" сэтгүүл, 1957. №7
- Пагба, 1957 - Т.Пагба, "ЗГТ-ыг судалсан тухай тэмдэглэл", УБ.
- Рерих, 1961 - Ю.Н.Рерих, "Тибетский язык", М.
- Төмөртогоо, 1973 - Д.Тумуртогоо, "О wa, we в "ЗТ" Сажа пандита Гунгаажалцана" - Олон улсын монголч эрдэмтэний II их хурал, боть II, УБ.х.163-165
- Төмөртогоо, 1981 - Д.Төмөртогоо, "Монгол хэлшинжилэлийн түүхэн уламжлал ба

Цэрэнпил, 1987 -	онолын үндэс" - Хэл зохиол судлал, XVII:5, х. 32-56 Д.Цэрэнпил, "Разделение звуков монгольского языка на гласные и согласные в комментариях к 'Jirüken-ü tolta' – Studia Mongolica, t. XII(20), 8 f. 14, p. 197-223.
Чойжинсамбу, 1526 -	zha lu lo tsa' ba chos skyong bsang po, bod kyi brda'i bstan bcos legs par bshad pa rin po che'i za ma tog bkod pa zhes bya ba, модон бар
Шагдарсүрэн, 1981 -	Ц.Шагдарсүрэн, "Монгол үсэг зүй", УБ.
Янжингавилодой	dbyangs can dga'i blo gros, rab gsal sgron me/ модон бар, б. 2 (kha)

Summary

Concerning the “Life-letter” in the comments of “Jirüken-ü tolta-yin tayilburi”

As the Mongolian historical sources say, Sakya-pandita Gungajaltsan has designed 44 basic letters of the Mongolian alphabet. But they provide the information in two ways: or only the number of the letters (44) is mentioned or all of the letters are given in the form of a syllable.

The researches have 2 basic opinions on how Sakya-pandita has received these 44 letters:

- Some 14 consonants vowelized with 3 vowels like *a, e, i* and excluding *wi*, 41 letters are received. Adding the mentioned 3 vowels to them he has gotten the 44.
- The Uighuric original 14 letters are vowelized with 3 vowels like *a, e, i* and adding two complexes, such as *wa, we* (they are not syllables-letters) 44 letters are received.

Analyzing these two approaches differing in principle one can be questioned with the following two thoughts:

- Is the consonant *w* included into the 14 consonants, which were vowelized above with the vowels *a, e, i* ? If it is, for what reason is the syllable-letter *wi* excluded? If it is not, for what reason the complexes *wa, we* are added?
- Regarding a vowelization of 14 Uighuric letters (*w* is not included) with the 3 vowels, how to comprehend that the first letter *a* of the 14, which seems to be a vowel, is vowelized with 3 vowels *a, e, i* ? What does this first letter present itself? A vowel? A consonant? Or something else?

The first thought was discussed in details by acad. D.Tumurtoogoo in his paper "Concerning *wa, we* in Sakya-pandita Gungajaltsan's 'Jirüken-ü Tolta-yin Tayilburi". Subtracting of *wi* is not a subject to be discussed since, as Agvaandandar claims, such a syllable-letter like *wi* doesn't exist in Mongolian at all, as well as the syllables, like *wo, wu, wu, wь*, which include labial vowels.

Actually, all the traditional grammars list vowels in the form with "titem" (throne) and consonants - in the form of a syllable. But there exists a grammatical work, where this tradition is ignored and both vowels and consonants are given not as syllables, but as separate sounds. This is a grammar by Biligiin Dalai (Saravjamts), who's ideas reflect the concepts of the earliest known grammarians of Mongolian, as Gungajaltsan and Choiji-Odsar.

In his grammar we can find a notion of "amin ʮᠰᠢᠭ" (life-letter), which he gives particularly in the book as a short teeth, when he lists letters one-by-one. This phenomenon reasons the following thoughts:

- The Biligiin Dalai's comment shows that the earlier grammarians of Mongolian comprehended a separate form of a vowel through the confound form like "amin ʮᠰᠢᠭ + a vowel", or in other words, as a kind of a syllable-letter.
- Biligiin Dalai gives the "amin ʮᠰᠢᠭ" not in the "titem" form, mechanically separated from its complex, but in the form of a short teeth, which tells for that it presents the first of the 14 Uighuric letters. It is certain that a "titem" is the latter form of the *a* letter from the Uighuric alphabet.
- Biligiin Dalai determines the "amin ʮᠰᠢᠭ" separately before he does vowels and refers for it as "there is a kind of ...", which says for that he consider "amin ʮᠰᠢᠭ" in a principal difference from ordinary vowels.

All of these allow us to conclude that "amin ʮᠰᠢᠭ" is the name of a letter *a* - the first of the 14 so-called Uighuric letters firstly adopted and laid in basics of the Mongolian script. It has two functions as follows:

1. It represents a vowel group in the alphabet. For example, "letters of an *a*" group means all the seven basic vowels.
2. It represent a head consonant vowelized by a particular vowel, when the separate form of a vowel is given in a written way as a syllable.